



ЮНЕСКО-ИЙН МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ
КОМИССЫН ДАРГА С.УЯНГА ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

2017.02.23 № 3/288
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.1, Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаархи мэдээлэл

ЮНЕСКО-ийн Монголын Үндэсний Комиссын удирдлага нь Төсвийн тухай хуулийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Нягтлан бодогчдын олон улсын холбооноос баталсан Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлж Монгол Улсын Үндэсний аудитын газраас гаргасан Санхүүгийн аудитын гарын авлагын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, гарын авлагын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн тайлан дахь дүн хэмжээ болон илчлэл тодруулгыг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгадаг. Түүнчлэн аудитаар удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн зарчим, хийсэн чухал тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлдэг.

Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

ЮНЕСКО-ийн Монголын Үндэсний Комиссын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, бодитой илэрхийлсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

[Signature]

Ц.НАРАНЧИМЭГ

\\10.10.10.20\Bichig_Kheregi\Yawsan_Bichig\2017\0225\AG4\Doc1

070271



УАГ
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

ЮНЕСКО-ГИЙН МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ КОМИССЫН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Аудитын тайлан

**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл дараах
хаягаар харилцана уу:**

Санхүүгийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор **Ц.Наранчимэг**
Утас: 261663

Аудитын менежер: **Я.Самбууням**
Утас: 261885

Шинжээч: **Б.Баярмаа**
Утас: 260512

Төрийн аудитын байгууллагын хаяг:
Үндэсний Аудитын Газар

Байршил:
Чингэлтэй дүүрэг

Цахим хуудас:
www.audit.mn

ГАРЧИГ

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Аудитын гэрчилгээ

Хавсралт 3: Менежментийн захидал

Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Хавсралт 5: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

2017 оны 2 дугаар сар

АГУУЛГА

1	Аудитын гэрчилгээ	3
2	Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл	4
3	Байгууллагын хууль, эрх зүйн орчин	4
4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа	5
5	Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн	5
6	Материаллаг байдлын түвшин	6
7	Дотоод хяналт	6
8	Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар	6
9	Шилэн дансны мэдээлэл	6
10	Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар	6
11	Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар	7
12	Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар	7
13	Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар	7
14	Анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
15	Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд	8
16	Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл	8
17	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	8
18	Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт	8
19	Менежментийн захидал	9
20	Аудитлагдсан санхүүгийн тайлан	12
21	Санхүүгийн тайлангийн тодруулга	18
22	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	21

ЮНЕСКО-ГИЙН МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ КОМИССЫН ЕРӨНХИЙ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА С.УЯНГА ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15.1, Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу ЮНЕСКО-гийн Монголын Үндэсний Комиссын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

ЮНЕСКО-гийн Монголын Үндэсний Комиссын удирдлага нь Төсвийн тухай хуулийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Нягтлан бодогчдын олон улсын холбооноос баталсан Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлж Монгол Улсын Үндэсний аудитын газраас гаргасан Санхүүгийн аудитын гарын авлагын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, гарын авлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг биднээс шаарддаг.

Аудитаар санхүүгийн тайлан дахь дүн хэмжээ болон илчлэл тодруулгыг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгадаг. Түүнчлэн аудитаар удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн зарчим, хийсэн чухал тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлдэг.

Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

ЮНЕСКО-гийн Монголын Үндэсний Комиссын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, бодитой илэрхийлсэн байна.

**САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР**

Ц.НАРАНЧИМЭГ

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл

Төсвийн тухай хуулийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1-д заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд ЮНЕСКО-гийн Монголын Үндэсний Комиссын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

ЮНЕСКО-гийн Монголын Үндэсний Комиссын 2016 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт оршино.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ЮНЕСКО-гийн Монголын Үндэсний Комиссын 2016 оны төсвийн санхүүгийн тайлангийн аудитыг 2017 оны 1 дүгээр сарын 30-аас 2-р сарын 8-ны хооронд хийхээр төлөвлөн, “Акпар-Аудит” компанийн ахлах аудитор М.Хосбаяраар удирдуулсан аудитын баг хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

ЮНЕСКО-гийн Монголын Үндэсний Комисс нь 2016 оны санхүүгийн тайланг 2017 оны 1 дүгээр сарын 25-нд “Акпар-Аудит” компанид ирүүлсэн байна.

“Акпар-Аудит” компани аудитын тайланг 2017 оны 2 дугаар сарын 13-ны дотор Үндэсний аудитын газарт хүргүүлэхээр төлөвлөсөн.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин

ЮНЕСКО-гийн Монголын Үндэсний Комисс нь Монгол улсын “Төсвийн тухай”, “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай”, “Нягтлан бодох бүртгэлийн тухай”, “Төрийн аудитын тухай” хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Тайланг онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж, түүнд нийцүүлэн гарсан журам, зааварт өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа

Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 1 дүгээр зүйлд “Төрийн болон орон нутгийн өмчийн эрх, төрийн эд хөрөнгийн талаар хууль тогтоох, гүйцэтгэх байгууллагын бүрэн эрх, төрийн өмчтэй хуулийн этгээд, түүний албан тушаалтны эрх, хэм хэмжээ, төрийн өмчийн талаарх бодлогыг хэрэгжүүлэх байгууллагын үйл ажиллагааны зарчим, журмыг тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино” гэж төрийн өмчит болон улсын төсвийн байгууллагын үйл ажиллагааны зорилтыг тодорхойлсон байна.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д “Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна” гэж заасан байна.

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.18-д “төсвийн бусад байгууллагын дарга (захирал, эрхлэгч) тухайн байгууллагын төсвийн шууд захирагч байна” гэж заасны дагуу ЮНЕСКО-гийн Монголын Үндэсний Комиссын Ерөнхий нарийн бичгийн дарга нь Төсвийн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна. ЮНЕСКО-гийн Монголын Үндэсний Комиссын 2016 оны төсвийг Гадаад хэргийн яамны төрийн сангаас олгож байна.

Төсвийн шууд захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

ЮНЕСКО-гийн Монголын Үндэсний Комиссын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар ЮНЕСКО-гийн Монголын Үндэсний Комиссын 2016 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил 46-г гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

ЮНЕСКО-гийн Монголын Үндэсний Комиссын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

ЮНЕСКО-гийн Монголын Үндэсний Комиссын санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн програмаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

Материаллаг байдлын түвшин

Материаллаг байдлын түвшинг төлөвлөлтийн үед тэвчиж болох хамгийн бага дүнгээр буюу нийт зардлын 0.2 хувиар авсан тул гүйцэтгэлээр мөн нийт зардлын 0,2 хувиар авахад 1,024,670.32 төгрөг байна.

Дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. ЮНЕСКО-гийн Монголын Үндэсний Комиссын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үед бага гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хэвийн байгаа ч дотоод аудитын нэгжгүй байна.

Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар

2016 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу салбарын яамны Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан, гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

ЮНЕСКО-гийн Монголын Үндэсний Комиссын 2016 онд урсгал зардлын төсвийг 141,650.1 мянган төгрөгөөр батласнаас 141,466.3 мянган төгрөг зарцуулж, батлагдсан төсвийг 183.8 мянган төгрөгөөр хэмнэсэн байна.

Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансанд цалингаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш дүнтэй зарлагын гүйлгээнүүд болон 2015 оны төсөв, түүний гүйцэтгэл, 2016 оны төсөв зэргийг байршуулсан байна.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 46 эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нарийвчилсан горимуудыг гүйцэтгэсэн.

Үр дагаварыг тодорхойлж чадвал: Дээрхи 46 эрсдлээс 4 зөрчил илрүүлж, илэрсэн зөрчлийг арилгах талаар зөвлөмж бичсэн ба 3 зөрчлийг санхүүгийн тайлан гаргахаас өмнө арилгасан.

Үлдсэн нэг зөрчил нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас гарах шийдвэртэй холбоотой учир 2017 оны эхний хагас жилд багтаан биелүүлэх зөвлөмж өгсөн.

Илрүүлсэн зөрчлүүдийн талаар “Асуудлын бүртгэл”-д тодорхой тусгасан болно.

Гол, онцлог гүйлгээний талаарх тайлбар

ЮНЕСКО-гийн Монголын Үндэсний Комиссын 2016 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, бараа материал, цалин хөлсний тооцоо зэрэг дансанд ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад материаллаг хэмжээний дараах алдаа илэрсэн байна. Үүнд:

1. Олон жил дамжсан, гадаад томилолт болон төсөл хөтөлбөртэй холбоотой 5,195,585.94 төгрөгийн авлага бүртгэлтэй явж ирсэн байна.

Шийдвэрлэсэн: Дээрхи олон жил дамжсан гадаад томилолт болон төсөл хөтөлбөрийн зардалтай холбоотой авлагыг урьдчилж төлсөн зардлын данс руу залруулж, байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хуралд оруулан хэлэлцүүлж, холбогдох зардал руу бичилт хийсэн.

2. Тус байгууллагын үндсэн хөрөнгөнд өмнөх ажлын байранд ашиглагдаж байсан ба дахин ашиглах боломжгүй болсон агааржуулах системтэй холбоотой хөрөнгүүд болон ашиглах хугацаа дуусч, эвдэрч муудсанаас цаашид ашиглагдах боломжгүй болсон анхны үнээр 8,361,067.00 төгрөгийн, үлдэгдэл өртгөөр 1,345,416.49 төгрөгийн үндсэн хөрөнгө бүртгэлтэй байна.

Шийдвэрлэсэн: Ажлын байрыг өөрчлөх үед хуучин байранд үлдсэн шилжүүлэн ашиглах боломжгүй агааржуулах систем болон хуучирч ашиглалтаас хасагдсан хөрөнгийг актлуулах саналыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлсэн байна. 2017 оны эхний хагас жилд багтаан биелүүлэх зөвлөмж өгсөн.

3. 2016 оны санхүүгийн тайлангийн эхний үлдэгдэл нь 2015 оны аудитлагдсан тайлангаас 608,044.09 төгрөгөөр зөрсөн байна.

Шийдвэрлэсэн: Зөрүүг арилгаж залруулан бичилт хийсэн.

4. 2016 онд нэг ажилтанд (тэтгэвэрийн насны) олгосон цалингаас суутгах хувь хүний орлогын албан татварыг буруу тооцож, 2016 оны эхний 10 сарын байдлаар 117,523.10 төгрөгийн татварыг дутуу суутгасан.

Шийдвэрлэсэн: Дутуу суутгасан татварыг 10, 11-р сарын цалингаас суутгасан.

Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар

Өөр залруулагдаагүй алдаа гараагүй.

Анхаарал татахуйц бусад чухал асуудал

Аудит хийх явцад анхаарал татахуйц бусад асуудал гараагүй.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд

Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар гэсэн хэсгийн 2-д дурьдсан үндсэн хөрөнгийг зөвлөмжинд заасан хугацаанд биелүүлсэн эсэхийг шалгах.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

ЮНЕСКО-гийн Монголын Үндэсний Комиссын 2016 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 7,266,569.62 төгрөгийн алдаа, зөрчил илэрсэнээс аудитад хамрагдсан хугацаанд 5,921,153.13 төгрөгийн алдаа, зөрчлийг арилгуулж, ашиглагдахгүй байгаа үндсэн хөрөнгийг актлуулах асуудлыг 2017 оны эхний хагас жилд багтаан шийдвэрлүүлэх зөвлөмж бичиж, хүргүүлсэн.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

ЮНЕСКО-гийн Монголын Үндэсний Комиссын 2015 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар “Акпар-Аудит” компаниас 2 зөвлөмж өгсөн ба бүрэн биелэгдсэн байна.

Д/д	Илэрсэн зөрчил	Өгсөн зөвлөмж	Биелэлт
1	Татварын байгууллагад 2014 онд 235.9 мянган төгрөгийн, 2015 онд 1,116.6 мянган төгрөгийн өртэй гарсан байна.	Татварын өрийг 2016 оны 1-р улиралд багтаан төлж барагдуулах.	2016 оны эцэст татварын өргүй гарсан.
2	2015 оны эцсийн байдлаар хувь хүнтэй холбоотой 2,931,510.94 төгрөгийн авлага байгаагийн дээр, төсөл хэрэгжүүлэгч нартай холбоотой 83,701,010.66 төгрөгийн авлага бүртгэгдсэн байна.	Хувь хүнтэй холбоотой авлагыг бүрэн барагдуулах. Төсөл хөтөлбөртэй холбоотой авлагыг бууруулах арга хэмжээ авах.	2016 оны эцэст хувь хүнээс авах авлагагүй болсон ба төсөл хөтөлбөртэй холбоотой авлага 80 хувиар буурсан.

Зөрчилгүй санал дүгнэлт

ЮНЕСКО-гийн Монголын Үндэсний Комиссын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, бодитой илэрхийлсэн байна.

Аудитын тайланг:

Хянасан:

Санхүүгийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор

Ц.Наранчимэг

Аудитын менежер:

Я.Самбууням

Бэлтгэсэн: “Акпар-Аудит” компанийн захирал

Х.Баянбай



УАГ
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

ЮНЕСКО-гийн Монголын Үндэсний Комисс

2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл дараах хаягаар харилцана уу: Санхүүгийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг Утас: 261663 Аудитын менежер: Я.Самбууням Утас: 261885 Шинжээч: Б.Баярмаа Утас: 260512 Төрийн аудитын байгууллагын хаяг: Үндэсний Аудитын Газар Байршил: Чингэлтэй дүүрэг Цахим хуудас: www.audit.mn	ТЭРГҮҮЛЭХ АЧ ХОЛБОГДОЛ № 1	Хуудас
	Асуудал 1	
	Зардлын шинжтэй авлагыг хаах	9
	Асуудал 2	
	Ашиглах боломжгүй болсон хөрөнгийг акталж данснаас хасах	10
	ТЭРГҮҮЛЭХ АЧ ХОЛБОГДОЛ № 2	
	Асуудал 3	
	Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүдийг аудитлагдсан тайлангаас зөрүүлэхгүй байх	10
	Асуудал 4	
	Татварыг зөв тооцож, суутгах	10
2017 оны 2 дугаар сар		

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Үндэсний аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг ЮНЕСКО-гийн Монголын Үндэсний Комиссын удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг ТАБ-ын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Төрийн аудитын байгууллага энэхүү зөвлөмжийг та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан ЮНЕСКО-гийн Монголын Үндэсний Комиссын санхүүгийн холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Асуудал 1

Зардлын шинжтэй авлагыг хаах		Тэргүүлэх ач холбогдол № 1	
Бодит байдал:		Зөвлөмж:	
Олон жил дамжсан гадаад томилолт болон төсөл хөтөлбөртэй холбоотой 5,195,585.94 төгрөгийн авлага бүртгэлтэй байна.		Олон жил дамжсан, хөөн хэлэлцэх хуулийн хугацаа нь дууссан, хариуцах эзэд нь тодорхойгүй, гадаад томилолт болон өмнө хэрэгжүүлж дууссан төсөл, хөтөлбөртэй холбоотой дээрхи авлагыг урьдчилж төлсөн зардлын данс руу залруулах. Мөн зардал бүрээр нь байгууллагын Өмч хамгаалах зөвлөлийн хуралд оруулан хэлэлцүүлж, жилийн эцсийн санхүүгийн тайлан гаргахаас өмнө холбогдох зардал рүү бичилт хийх.	
Эрсдэлүүд:		Үйлчлүүлэгчийн хариу:	
Зардлын шинжтэй авлага хөрөнгө биш учир байгууллагын нийт хөрөнгийг хий өсгөж харуулдаг.		Авлагын дансанд буруу бүртгэгдсэн урьдчилж төлсөн зардлыг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хуралд оруулан хэлэлцүүлж, холбогдох зардал руу бичилт хийсэн.	

Асуудал 2

Ашиглах боломжгүй болсон хөрөнгийг акталж данснаас хасах		Тэргүүлэх ач холбогдол № 1	
Бодит байдал:		Зөвлөмж:	
Тус байгууллагад өмнөх ажлын байранд ашиглагдаж байсан ба дахин ашиглах боломжгүй болсон агааржуулах системтэй холбоотой хөрөнгүүд болон ашиглах хугацаа дуусч, эвдэрч муудсанаас цаашид ашиглагдах боломжгүй болсон анхны үнээр 7,454,068.00 төгрөгийн, үлдэгдэл өртгөөр 1,434,228.94 төгрөгийн үндсэн хөрөнгө бүртгэлтэй байна.		Ашиглагдах боломжгүй болсон үндсэн хөрөнгийг зохих журмын дагуу 2017 оны эхний хагас жилд багтаан актлуулах арга хэмжээ авах.	
Эрсдэлүүд:		Үйлчлүүлэгчийн хариу:	
Ашиглах боломжгүй хөрөнгийг бүртгэл, дансанд тусгасанаар хөрөнгийн үлдэгдэл илүү илэрхийлэгдэж, нийт хөрөнгийн хэмжээ, нөөцийг тооцоолоход сөрөг нөлөө үзүүлнэ.		Зохих журмын дагуу Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт бичиг явуулсан.	

Асуудал 3

Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүдийг аудитлагдсан тайлангаас зөрүүлэхгүй байх		Тэргүүлэх ач холбогдол № 2	
Бодит байдал:		Зөвлөмж:	
2016 оны санхүүгийн тайлангийн эхний үлдэгдэл нь 2015 оны аудитлагдсан тайлангаас 608,044.09 төгрөгөөр зөрсөн байна.		Залруулан бичилт хийх. Цаашид санхүүгийн тайлангийн үзүүлэлтийг аудитлагдсан тайлангаас зөрүүлэхгүй байх.	
Эрсдэлүүд:		Үйлчлүүлэгчийн хариу:	
Холбогдох стандарт, хуулийн заалтыг зөрчсөн		Зөрүүг арилгаж, залруулан бичилт хийсэн.	

Асуудал 4

Татварыг зөв тооцож, суутгах		Тэргүүлэх ач холбогдол № 2	
Бодит байдал:		Зөвлөмж:	
2016 онд нэг ажилтанд (тэтгэвэрийн насны) олгосон цалингаас суутгах хувь хүний орлогын албан татварыг буруу тооцож, 2016 оны эхний 10 сарын байдлаар 117,523.10 төгрөгийн татварыг дутуу суутгасан.		Дутуу суутгасан татварын зөрүүг дахин суутгаж, зөрчлийг арилгах.	
Эрсдэлүүд:		Үйлчлүүлэгчийн хариу:	
Нөхөн татвар, алданги төлөх эрсдэлтэй.		Дутуу суутгасан татварыг 10, 11-р сарын цалингаас суутгасан.	

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Балансын зүйл	Өмнөх он	Тайлант он
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ		
МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	500,007.50	200.90
Кассад байгаа бэлэн мөнгө	500,007.50	200.90
Жижиг мөнгөн сан		
Банкинд байгаа бэлэн мөнгө /төгрөгөөр/		
Улсын төсвийн харилцах		
Тусгай зориулалтын сангийн харилцах		
Замд яваа мөнгөн хөрөнгө		
Богино хугацаат хадгаламж		
АВЛАГА	147,968,467.69	29,428,374.37
Төлбөртэй үйлчилгээний авлага		
Бусад авлага	147,968,467.69	29,428,374.37
УРЬДЧИЛЖ ТӨЛСӨН ТӨЛБӨР	0.00	0.00
Урьдчилгаа тооцоо		
Урьдчилж гарсан зардал		
БАРАА МАТЕРИАЛ	1,472,405.71	2,514,355.70
Түүхий эд материал		
Дуусаагүй үйлдвэрлэл		
Бэлэн бүтээгдэхүүн		
Хангамжийн материал	55,464.04	464,139.03
Мал, амьтад		
Бусад	1,416,941.67	2,050,216.67
НӨӨЦИЙН БАРАА		
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	149,940,880.90	31,942,930.97
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ		
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	53,049,632.48	41,433,755.64
Биет хөрөнгө	53,040,007.32	41,433,755.64
Барилга, байгууламж		
Хуримтлагдсан элэгдэл		
Авто-тээврийн хэрэгсэл	55,000,000.00	55,000,000.00
Хуримтлагдсан элэгдэл	(16,041,666.69)	(25,208,333.37)
Машин тоног төхөөрөмж	30,692,149.00	30,692,149.00
Хуримтлагдсан элэгдэл	(30,692,149.00)	(30,692,149.00)
Тавилга, аж ахуйн эд хогшил	19,247,147.00	19,247,147.00
Хуримтлагдсан элэгдэл	(10,137,099.69)	(12,061,814.73)
Түүх соёлын дурсгалт зүйлс		
Хуримтлагдсан элэгдэл		
Номын фонд	269,500.00	269,500.00
Хуримтлагдсан элэгдэл		
Бусад үндсэн хөрөнгө	8,507,319.00	8,507,319.00
Хуримтлагдсан элэгдэл	(3,805,192.30)	(4,320,062.26)
Дуусаагүй барилга, байгууламж		

Биет бус хөрөнгө	9,625.16	0.00
Программ хангамж	770,000.00	770,000.00
Хуримтлагдсан элэгдэл	(760,374.84)	(770,000.00)
БУСАД ХӨРӨНГӨ		
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	53,049,632.48	41,433,755.64
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	202,990,513.38	73,376,686.61
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		
Өглөг	62,452,589.02	29,428,374.37
Ажиллагсадтай холбогдсон өглөг	1,116,642.93	
НДШ-ийн өглөг		
ХХОАТ-ын өглөг		
Татаас, санхүүжилтийн өглөг		
Бусад өглөг	61,335,946.09	29,428,374.37
Урьдчилж орсон орлого		
Урьдчилгаа- Төсвийн татаас		
Бусад урьдчилж орсон орлого		
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	62,452,589.02	29,428,374.37
Урт хугацаат зээл		
УРТ ХУГАЦААТ ӨР, ТӨЛБӨРИЙН ДҮН	0.00	0.00
НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	62,452,589.02	29,428,374.37
ЭЗДИЙН ӨМЧ		
Засгийн газрын хувь оролцоо	78,398,015.00	78,398,015.00
Хуримтлагдсан үр дүн	62,139,909.36	(34,449,702.76)
Өмнөх үеийн үр дүн	(448,841.22)	61,531,865.27
Тайлант үеийн үр дүн	62,588,750.58	(95,981,568.03)
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		
ЦЭВЭР ХӨРӨНГӨ / ӨМЧИЙН ДҮН	140,537,924.36	43,948,312.24
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ / ӨМЧИЙН ДҮН	202,990,513.38	73,376,686.61

Хавсралт тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО		
ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		
Улсын төсвөөс	160,616,900.00	141,650,100.00
Урсгал	160,616,900.00	141,650,100.00
Хөрөнгийн		
Бусад төсөвт байгууллагаас		
Төсөвт байгууллагын ажил, үйлчилгээний орлого	511,718,537.59	274,703,492.14
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	511,079,493.50	274,601,364.14
Бусад	639,044.09	102,128.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	672,335,437.59	416,353,592.14
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ		
АЖИЛЛАГСАДТАЙ ХОЛБОГДСОН ЗАРДАЛ	106,027,269.79	96,922,112.98
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшуулал	95,393,729.65	87,156,251.91
Цалин	86,206,729.65	75,381,851.91
Бусад нэмэгдлүүд	9,187,000.00	11,774,400.00
Нийгмийн даатгал	10,633,540.14	9,765,861.07
Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл	8,700,169.22	8,127,289.50
Эрүүл мэндийн даатгалын хураамж	1,933,370.92	1,638,571.57
БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ УРСГАЛ ЗАРДАЛ	503,719,417.22	415,413,047.19
Тогтмол зардал	12,289,680.20	10,683,992.00
Гэрэл цахилгааны зардал		
Байрны түрээсийн зардал	12,289,680.20	10,683,992.00
Хангамжийн зардал	4,850,322.94	6,294,702.01
Бичиг хэргийн материал	695,650.00	2,066,349.00
Тээвэр, шатахууны зардал	2,921,620.00	2,877,653.01
Шуудан холбооны зардал	1,233,052.94	1,350,700.00
Томилолтын зардал	12,908,550.00	3,375,866.94
Гадаад албан томилолтын зардал	12,096,000.00	2,695,585.94
Дотоод албан томилолтын зардал	234,500.00	146,200.00
Гадаад зочны зардал	578,050.00	534,081.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардал	24,395,630.00	26,704,340.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ	24,175,630.00	26,414,200.00
Даатгал	200,000.00	177,240.00
Тээврийн хэрэгслийн оношилгоо	20,000.00	112,900.00
Бусад зардал	449,275,234.08	368,354,146.24
Элэгдлийн зардал	13,601,748.13	11,615,876.84
Бусад төсөл арга хэмжээний зардал	434,342,156.86	355,968,905.73
Төрийн өмчит байгууллагад олгосон санхүүжилт		
Төвлөрүүлсэн мөнгө	971,329.09	769,363.67
Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал	360,000.00	
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	609,746,687.01	512,335,160.17
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	62,588,750.58	(95,981,568.03)
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГО		

Гадаад валютын ханшийн зөрүүний олз (бодит)

Үндсэн хөрөнгө худалдсаны олз

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН (IV)	0.00	0.00
---	-------------	-------------

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ

Бараа материал худалдсаны гарз

Үндсэн хөрөнгө худалдсаны гарз

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)	0.00	0.00
--	-------------	-------------

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	62,588,750.58	(95,981,568.03)
------------------------------------	----------------------	------------------------

Хавсралт тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
Татаас, санхүүжилтийн орлого	160,616,900.00	141,650,100.00
Улсын төсвөөс	160,616,900.00	141,650,100.00
Урсгал	160,616,900.00	141,650,100.00
Хөрөнгийн		
Бусад төсөвт байгууллагаас		
Төсөвт байгууллагын ажил, үйлчилгээний орлого	511,656,197.59	304,615,537.35
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	511,017,153.50	304,529,738.51
Бусад	639,044.09	85,798.84
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	672,273,097.59	446,265,637.35
Ажиллагсадтай холбогдсон зардал	105,449,041.86	98,128,073.17
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшуулал	94,924,041.86	88,322,695.54
Цалин	83,149,641.86	76,548,295.54
Бусад нэмэгдлүүд	11,774,400.00	11,774,400.00
Нийгмийн даатгал	10,525,000.00	9,805,377.63
Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл	8,611,363.66	8,685,116.53
Эрүүл мэндийн даатгалын хураамж	1,913,636.34	1,120,261.10
БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ УРСГАЛ ЗАРДАЛ	566,324,531.09	348,637,370.78
Тогтмол зардал	12,289,680.20	10,683,992.00
Гэрэл цахилгааны зардал		
Байрны түрээсийн зардал	12,289,680.20	10,683,992.00
Суваг ашигласны түрээсийн зардал		
Хангамжийн зардал	4,387,702.94	5,269,649.00
Бичиг хэргийн материал	695,650.00	869,649.00
Тээвэр, шатахууны зардал	2,459,000.00	3,049,300.00
Шуудан холбооны зардал	1,233,052.94	1,350,700.00
Томилолтын зардал	12,908,550.00	680,281.00
Гадаад албан томилолтын зардал	12,096,000.00	
Дотоод албан томилолтын зардал	234,500.00	146,200.00
Гадаад зочны зардал	578,050.00	534,081.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардал	24,395,630.00	26,704,340.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ	24,175,630.00	26,414,200.00
Даатгал	200,000.00	177,240.00
Тээврийн хэрэгслийн оношилгоо	20,000.00	112,900.00
Бусад зардал	512,342,967.95	305,299,108.78
Бусад төсөл арга хэмжээний зардал	511,011,638.86	275,101,370.74
Төрийн өмчит байгууллагад олгосон санхүүжилт		
Төвлөрүүлсэн мөнгө	971,329.09	30,197,738.04
Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал	360,000.00	
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (II)	671,773,572.95	446,765,443.95
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	499,524.64	(499,806.60)
Хөрөнгийн орлого /ХО-ийн санхүүжилт/		
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	0.00	0.00

Биет ба биет бус хөрөнгө худалдан авах зардал

Хөрөнгийн бусад зардал

**ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН
(V)**

0.00

0.00

**ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ
(VI)=(IV)**

-

-

**САНХҮҮГИЙН АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН
ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН**

0.00

0.00

НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (IX)=(VII)+(VIII)

499,524.64

(499,806.60)

Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл

482.86

500,007.50

Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл

500,007.50

200.90

Хавсралт тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

СТ-4А

АУДИТ ХИЙГДСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцоо	Хуримтлагдсан	Дүн
2014 оны 12 сарын 31-ээрх үлдэгдэл	78,398,015.00	(448,841.22)	15,215,133,358.85
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл			
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт			
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт			
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз			
Тайлант үеийн үр дүн		62,588,750.58	62,588,750.58
2015 оны 12 сарын 31-ээрх үлдэгдэл	78,398,015.00	62,139,909.36	140,537,924.36
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл		(608,044.09)	(608,044.09)
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт			
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт			
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз			-
Тайлант үеийн үр дүн		(95,981,568.03)	(95,981,568.03)
2016 оны 12 сарын 31-ээрх үлдэгдэл	78,398,015.00	(34,449,702.76)	43,948,312.24

Хавсралт тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ТОДРУУЛГА

Санхүүгийн тайланд тусгагдсан хөрөнгө болон түүний эх үүсвэрийн үлдэгдэл дараах байдалтай байна. Үүнд:

Мөнгөн хөрөнгө

Тус ажлын алба нь Төрийн санд Төсвийн болон ЮНЕСКО-гийн санхүүжилтийн 2 харилцах данстай. Арилжааны банкуудад харилцах данс нээлгээгүй.

Үзүүлэлт	2015 он	2016 он
Бэлэн мөнгө		
Кассанд байгаа бэлэн мөнгө	500,007.50	200.90
Бэлэн мөнгөний дүн	500,007.50	200.90
Банкин дахь мөнгөн хөрөнгө		
Төрийн сан-Нэмэлт санхүүжилтийн харилцах		
Төрийн сан-Төсвийн харилцах		
Банкин дахь мөнгөн хөрөнгийн дүн	0.00	0.00
Нийт мөнгөн хөрөнгийн дүн	500,007.50	200.90

Дансны авлага

Ажиллагсадад олгосон урьдчилгаа болон төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэгч нарт олгосон санхүүжилтийг авлагаар бүртгэсэн байна. 2016 оны эцэст ажиллагсадаас авах авлагыг бүрэн барагдуулсан байна.

Үзүүлэлт	2015 он	2016 он
Ажиллагсадтай холбоотой авлага	235,925.00	
Төсөл хэрэгжүүлэгчээс авах авлага	2,500,000.00	
Хувь хүнээс авах авлага	2,695,585.94	
Төрийн сангаас авах авлага	142,536,956.75	29,428,374.37
Дүн	147,968,467.69	29,428,374.37

Бараа материал

Байгууллагын үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах зорилгоор бэлтгэсэн хангамжийн материал, шатахуун зэргийг бараа материалын дансанд бүртгэсэн байна.

Бараа материалын үлдэгдэл дараах байдалтай байна.

Үзүүлэлт	2015 он	2016 он
Хангамжийн материал	1,416,941.67	2,050,216.67
Шатахуун	55,464.04	464,139.03
Бараа, үйлчилгээний зардлын дүн	1,472,405.71	2,514,355.70

Үндсэн хөрөнгө

2016 онд үндсэн хөрөнгийн бүрэлдэхүүнд өөрчлөлт ороогүй байна.

Хөрөнгийн Ангилал	Оны эхний үлдэгдэл	Өөрчлөлт		Оны эцсийн үлдэгдэл
		Нэмэгдсэн	Хасагдсан	
Тээврийн хэрэгсэл	55,000,000.00			55,000,000.00
Тоног төхөөрөмж	30,692,149.00			30,692,149.00
Тавилга эд хогшил	19,247,147.00			19,247,147.00
Ном	269,500.00			269,500.00
Бусад үндсэн хөрөнгө	8,507,319.00			8,507,319.00
Программ хангамж	770,000.00			770,000.00
Үндсэн хөрөнгийн дүн	114,486,115.00			114,486,115.00

Үндсэн хөрөнгийн элэгдэл

Үндсэн хөрөнгийн элэгдлийг ашиглах хугацааг үндэслэн шулуун шугамын аргаар байгуулсан байна.

Үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдлийн үлдэгдэл дараах байдалтай байна.

Хөрөнгийн ангилал	Оны эхний үлдэгдэл	Өөрчлөлт		Оны эцсийн үлдэгдэл
		нэмэгдсэн	Хасагдсан	
Тээврийн хэрэгсэл	16,041,666.69	9,166,666.68		25,208,333.37
Тоног төхөөрөмж	30,692,149.00	0.00		30,692,149.00
Тавилга эд хогшил	10,137,099.69	1,924,715.04		12,061,814.73
Ном				
Бусад үндсэн хөрөнгө	3,805,192.30	514,869.96		4,320,062.26
Программ хангамж	760,374.84	9,625.16		770,000.00
Үндсэн хөрөнгийн элэгдлийн дүн	61,436,482.52	11,615,876.84		73,052,359.36
Үлдэгдэл өртөг	53,049,632.48			41,433,755.64

Богино хугацаат өглөг

Ажиллагсдад өгөх өглөг болон төсөл хөтөлбөртэй холбоотой өглөгийг богино хугацаат өглөгөөр бүртгэсэн байна.

Үзүүлэлт	2015 он	2016 он
Ажиллагсдад өгөх өглөг	1,116,642.93	
Байгууллагад өгөх өглөг	61,335,946.09	29,428,374.37
Дүн	62,452,589.02	29,428,374.37

Тус ажлын албаны 2016 оны санхүүжилт, түүний зарцуулалт дараах байдалтай байна.

Нийт орлого

Үзүүлэлт	2015 он	2016 он
Урсгал зардлын санхүүжилт	160,616,900.00	141,650,100.00
Хөрөнгө оруулалтын санхүүжилт		
Хөтөлбөр арга хэмжээний санхүүжилт	511,079,493.50	274,601,364.14
Бусад орлого	639,044.09	102,128.00
Нийт орлогын дүн	672,335,437.59	416,353,592.14

Нийт зардал

Үзүүлэлт	2015 он	2016 он
Цалин	86,206,729.65	75,381,851.91
Бусад нэмэгдлүүд	9,187,000.00	11,774,400.00
Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл	8,700,169.22	8,127,289.50
Эрүүл мэндийн даатгалын хураамж	1,933,370.92	1,638,571.57
Байрны түрээсийн зардал	12,289,680.20	10,683,992.00
Бичиг хэргийн материал	695,650.00	2,066,349.00
Тээвэр, шатахууны зардал	2,921,620.00	2,877,653.01
Шуудан холбооны зардал	1,233,052.94	1,350,700.00
Гадаад албан томилолтын зардал	12,096,000.00	2,695,585.94
Дотоод албан томилолтын зардал	234,500.00	146,200.00
Гадаад зочны зардал	578,050.00	534,081.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ	24,175,630.00	26,414,200.00
Даатгал шимтгэл	200,000.00	177,240.00
Тээврийн хэрэгслийн оношилгоо	20,000.00	112,900.00
Элэгдлийн зардал	13,601,748.13	11,615,876.84
Бусад төсөл арга хэмжээний зардал	434,342,156.86	355,968,905.73
Төрийн өмчит байгууллагад олгосон санхүүжилт		
Төвлөрүүлсэн мөнгө	971,329.09	769,363.67
Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал	360,000.00	
Дүн	609,746,687.01	512,335,160.17

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ УРСГАЛ ЗАРДЛЫН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

Гадаад хэргийн сайдын багцад багтах ЮНЕСКО-гийн Монголын Үндэсний Комиссын 2016 оны урсгал зардлын төсвийн гүйцэтгэл дараах байдалтай байна.

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл		500,007.50		
Төсвийн санхүүжилт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Урсгал зардлын санхүүжилт	141,950,100.00	141,650,100.00	(300,000.0)	99.79
Төсвийн орлогын дүн	141,950,100.00	141,650,100.00	(300,000.00)	99.79
Төсөл арга хэмжээний орлого		304,529,738.51		
Бусад орлого		85,798.84		
Нийт мөнгөн орлогын дүн		446,265,637.35		
Зардлын нэр төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Цалин	76,592,300.00	76,548,295.54	(44,004.46)	99.94
Бусад нэмэгдлүүд	11,774,400.00	11,774,400.00		100.00
Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл	8,024,100.00	8,685,116.53	661,016.53	108.24
Эрүүл мэндийн даатгалын хураамж	1,783,200.00	1,120,261.10	(662,938.90)	62.82
Байрны түрээсийн зардал	10,684,900.00	10,683,992.00	(908.00)	99.99
Бичиг хэргийн материал	870,100.00	869,649.00	(451.00)	99.95
Тээвэр, шатахууны зардал	3,049,300.00	3,049,300.00		100.00
Шуудан холбооны зардал	1,350,700.00	1,350,700.00		100.00
Дотоод албан томилолт	174,400.00	146,200.00	(28,200.00)	83.83
Гадаад зочны зардал	510,500.00	534,081.00	23,581.00	104.62
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ	25,416,200.00	25,414,200.00	(2,000.00)	99.99
Аудит баталгаажуулалт	1,100,000.00	1,000,000.00	(100,000.00)	90.91
Даатгал шимтгэл	200,000.00	177,240.00	(22,760.00)	88.62
Тээврийн хэрэгслийн татвар, оношилгоо	120,000.00	112,900.00	(7,100.00)	94.08
Төсөвт зардлын дүн	141,650,100.00	141,466,335.17	(183,764.83)	99.87
Төсөвт төвлөрүүлсэн		30,197,738.04		
Төсөл арга хэмжээ		275,101,370.74		
Мөнгөн хөрөнгийн нийт зарцуулалт		446,765,443.95		
Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл		200.90		

“АКПАР-АУДИТ” КОМПАНИ